

---

А М Ъ Д Б О Ш И Г Л О Г Ч Д Ы Н З А А Д А Г З Ү Й Л С

---

Б А Г Ш И Й Н У Д И Р Д А М Ж Ш А Ш И Н 3 3 3



---

# Амьд Бошиглогчдын Заадаг Зүйлс

---

Багшийн Удирдамж Шашин 333

© 1986

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Бүх Эрх Хамгаалагдсан

АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 5/86

Орчуулгын зөвшөөрөл: 5/86

*Teachings of the Living Prophet: Instructor's Guide*-ийн орчуулга.

Mongolian

---

# Гарчиг

---

Оршил .....	v	Бүлэг 9 Сонголт хийгээд Дуулгавартай байдал .....	14
Бүлэг 1 Удиртгал .....	1	Бүлэг 10 Бошиглогчдыг Дэмжин Батлах нь Ямар Утгатай вэ? .....	15
Бүлэг 2 Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчид Гэж Хэн бэ? .....	3	Бүлэг 11 Бошиглогчдыг Дагах ба Эсэргүүцэхийн Үр Дагаврууд .....	17
Бүлэг 3 Амьд Бошиглогч .....	5	Бүлэг 12 Сүмийн Чуулгануудын Зорилго, Ач Холбогдол .....	18
Бүлэг 4 Амьд Бошиглогч хийгээд Судар .....	7	Бүлэг 13 Чуулганы Илтгэлүүдэд Хэрхэн Шинжилгээ хийж, мөн Ашиглах вэ? .....	19
Бүлэг 5 Тэргүүн Зөвлөл .....	8		
Бүлэг 6 Арванхоёрын Чуулга .....	9		
Бүлэг 7 Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх Залгамжлал .....	11		
Бүлэг 8 Зөв Үзэл Баримтлал: Худал Хуурмагийн Эсрэг Хамгаалалт .....	12		

# Оршил

Амьд Бошиглогчдын заадаг зүйлүүд нь амьд сүмийн амьд бошиглогчдын заадаг зүйлүүд дээр гол анхаарлаа хандуулсан өвөрмөц цуврал хичээл юм. Тус цуврал хичээлийн зорилго нь Бурхан өөрийн оюун ухаан болон хүслээрээ газар дэлхий дээрх өөрийн хүүхдүүдтэй байнгын үндсэн дээр харьцдаг мөн газар дэлхий дээр амьд бошиглогчид оршиж илчлэлт хүлээн авдгийг оюутнуудад ойлгуулахад оршино.

Багшийн Удирдамж нь *Амьд Бошиглогчдын Заадаг Зүйлс* (Шашин 333, оюутны гарын авлага, 1982)-ын арвангурван бүлэгт дүйсэн арвангурван бүлэгтэй юм. Бүлэг бүр нь доорх зүйлийг агуулсан байдаг:

*Заах Зорилго.* Энэ товч мэдэгдэл нь оюутнуудын сурах ёстой гол санааг нэгтгэн дүгнэдэг.

*Товч утгын жишээ.* Энэ хэсэг нь хичээлд юу заагдах ёстой талаарх жишээнүүдийг агуулдаг. Энэ нь хичээлд бэлтгэх зарим нэгэн заавар өгөх ёстой ч та нарын бүтээлч байдлыг ямар нэг хэмжээгээр хязгаарлах ёсгүй.

*Заах зөвлөмжүүд.* Энэ хэсэг нь та нар хичээлээ бэлтгэхдээ хэрэглэж болохуйц олон янзын санаанууд эсвэл заах аргуудыг агуулдаг. Энэ санаанууд нь ямар нэг дэс дараатай эмх цэгцтэй өгөгдсөн байдаггүй. Зорилго нь ердөө л та нарыг тухайн бүлгийг заахдаа та нарын сонгох олон янзын санаануудаар хангах явдал юм.

Хичээл нь судлах гурван бүлгээс бүрдэнэ:

*Оюутны гарын авлага.* Оюутнуудад өөрсдийн амьд бошиглогчидтой харилцах харилцаа мөн амьд

бошиглогчдын үүрэг ба зөвлөгөөний тухай зарим үндсэн ойлголтыг ойлгоход тусална. Оюутны гарын авлага нь энэ хичээлд зориулагдан бэлтгэгдсэн болно. Энэ нь бошиглогчид одоо юуг зааж байгааг танилцуулахад ашиглагдах юм. Та нар хичээлийн эхний хагасын туршид оюутны гарын авлага дахь бүлэг 1–12-ын материалыг ярилцах ёстой. Ингэснээр үлдсэн хичээл нь бошиглогчдын жинхэнэ заавруудыг суралцахад хэрэглэгдэж болно.

*Хамгийн сүүлчийн чуулганы илтгэл.* Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн бүхий л зааврууд нь гайхамшигтай үнэ цэнэтэй хэдий ч энэ хичээлээр оюутнууд Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын заавруудыг судлах ёстой. Хамгийн сүүлчийн чуулганы илтгэлийг олуулахаар оюутнуудад *Ensign*-ий хувиудыг хүртээмжтэй болго. Тэднийг ангиас гадуур суралцаж мөн үүнийгээ дараагийн лавлагаанд зориулан тэмдэглэгээ хийж болох хувийг өөртөө худалдан авахыг нь урамшуул. Багшийн удирдамжийн бүлэг 13 нь чуулганы илтгэлүүдийг оюутнуудад хэрхэн задлан шинжлэхийг заах зөвлөгөөнүүдийг агуулдаг.

*Асуудлууд ба сэдвүүд.* Сэдвийн ном зүйд хорин есөн ном жагсаагдсан бөгөөд бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчдийн сэтгэл зовоосон зүйлсийн хэлэлцэх асуудалд манай өнөө үед өгсөн зөвлөгөөнүүдийн жагсаалтуудын лавлагаа юм. Хичээлийн энэ хэсгийг хэрхэн үзүүлэх зөвлөгөө бүлэг 13-ийг ярилц.

## Заах Зорилго

Оюутнууд орчин үеийн бошиглогчдын үгсийг судалснаас ирэх олон ашиг тусыг мэдэж авах ёстой.

## Товч Утгын Жишээ

- А. Бид өнөөдөр дэлхий дээр тулгараад байгаа маш олон чадал сорьсон болоод ноцтой асуудлуудтай тулгараад байна.
- Б. Өнгөрсөн үеүдэд, Бурхан өөрийн хүүхдүүдэд хожмын өдрүүдэд удирдамж ба заавар өгүүлэхээр бошиглогчдыг дуудсан.
- В. Амьд бошиглогчдын зааврыг дуулгавартай дагаж суралцдаг тэдгээр нь адислагддаг.

## Заах Зөвлөмжүүд

- Сонин сэтгүүлүүдийн өгүүлэл эсвэл радио телевизийн мэдээнээс хүн төрөлхтөнд сүүлийн үед тулгараад байгаа олон тооны ноцтой асуудлуудыг олоод үзүүлж тайлбарла.
- Оюутнуудаас манай өнөө үед тулгараад байгаа хамгийн агуу зарим нэг бэрхшээлүүдийг юу гэж тэд үздэгийг асуу. Оюутнуудын хариултуудыг самбарт бичиж болно. Оюутнууд санаа бодлоо илэрхийлсний дараа тэднээс бидний хамгийн тулгамдсан хэрэгцээ юу болохыг асуу.

Өнөөдрийн бэрхшээлүүд

- |   |   |   |
|---|---|---|
| <ul style="list-style-type: none"><li>1.</li><li>2.</li><li>3.</li><li>4.</li></ul> | } | Бидний хамгийн чухал хэрэгцээ бол амьд бошиглогчдын дууг сонсож, дуулгавартай дагах явдал юм. |
|---|---|---|

- Оюутны гарын авлага 1-1 дээрх Ахлагч Хю Б.Брауны ишлэлийг оюутнуудтай ярилц. Та нар шүүгчийн сүүлийн мэдэгдэлд анхаарлаа төвлөрүүлж ярилцлага хийж болно: “Ноён Браун, дэлхийн түүхэнд Бурханы үг одоо бидэнд хэрэгтэй байгаа шиг тийм цаг үе байсангүй” (*The Profile of a Prophet, Brigham Young University Speeches of the Year* [Provo, 4 Oct. 1955], p. 5).

Энэ тохиолдол нь Дэлхийн II Дайны өмнө болсон юм. Тэр үед байснаас яагаад энэ нь одоо илүү хамааралтай байна вэ?

- Энэ эрин үед Сүмийн Ерөнхийлөгчөөр үйлчилсэн арвангурван эрэгтэй хүний нэрийг дэс дарааллаар нь нэрлэж чадах эсэхийг оюутнуудаас асуу. Газар дэлхийд амьдрах нь ямар их сэтгэл

хөдөлгөсөн цаг үе болохыг оюутнуудад гарган хэл. Хэдийгээр энэ цаг үе нь ёс бус явдал, гэмт хэргийн үе боловч энэ үе нь амьд бошиглогчидтой тэд Их Эзэний ажлыг удирдан, чиглүүлдэг цаг үе юм. 1835 оны хоёрдугаар сарын 14-ны өдрийн Арванхоёрын Чуулгын анхны дуудлагаас хойш 1985 оны төгсгөл хүртэл наян долоон эрэгтэй хүн энэ чуулгад үйлчилсэн байна.

- Судрууд дээрээс хүмүүс тусламжгүй нөхцөл байдалд байж асуудлуудаа өөрсдөө шийдвэрлэж чадахгүй байсан жишээнүүдийг оюутнуудынхаа хамт анхааран үз.

Зөвхөн Их Эзэний тусламжтайгаар тэд асуудлуудыг амжилттай шийдвэрлэх боломжтойг гарган хэл.

*Египетээс гарсан нь* 7–12. Израилчууд Египетийн боолчлолоос чөлөөлөгдөв.

*Египетээс гарсан нь* 14. Израилчууд Улаан Тэнгисээр удирдагдан гарав.

*Шүүгчид* 6–8. Мидианыг ялахад нь Гидеон Израилчуудад тусалжээ.

*Хаадын дэд* 5. Нааман уяман өвчнөөсөө эдгэрсэн байв.

*Хаадын дэд* 6:8–23. Сирийн армиас зугтахад нь Елиша Израилчуудад тусалжээ.

*Хаадын дэд* 19:14–36. Их Эзэн Иерусалимыг Ассиричуудаас аварчээ.

*Естер* 4–8. Бурханд итгэх Естерийн итгэл түүний хүмүүсийг аврав.

*Даниел* 1. Даниел болон түүний найзууд хааны зоогийг идэхээс татгалзсанаараа дэмжигджээ.

*Даниел* 3. Бурхан Шадрах, Мешах, Абед-него нарыг дүрэлзсэн галтай зуухнаас авран хамгаалав.

*Даниел* 6. Даниел арслангийн үүрнээс чөлөөлөгджээ.

*3 Нифай* 1. Итгэлтэй Нифайчууд Аврагчийн төрөлтийн тэмдгээр устгалаас хамгаалагдан үлджээ.

Дараах зарчмуудыг ойлгоход нь оюутнуудад тусал:

1. Бурхан өөрийн бүх хүүхдүүдэд хайртай.
2. Бурхан өчигдөр, өнөөдөр мөн үүрд нэгэн адил.
3. Их Эзэн өнгөрсөн үед хийж байсан шигээ өнөөдөр өөрийн хүмүүсийг аварч мөн хамгаалах болно.

- Сургаал ба Гэрээ 1:17–23-ыг оюутнуудтайгаа уншиж ярилц. Бурхан яагаад Иосеф Смитийг бошиглогчоор дуудсан бэ? Тэр дуудлагын үр дүн юу байх вэ?

- Оюутны гарын авлага 1-2 дахь Спенсер В.Кимбаллын ерөнхий чуулганы тухай мэдэгдлийн ач холбогдлыг ярилц.

■ Доорх ишлэлд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга байсан Күрт Валдхеймийн мэдэгдлийг Ерөнхийлөгч Марион Ж.Ромни давтсан байна.

“ Дэлхийд одоо давамгайлаад байгаа зүйлийн талаар хаа сайгүй байгаа үүрэг хариуцлагатай хүмүүст хуваалцах учиртай өөрийнхөө тэрхүү хүчтэй сэтгэл зовинолыг би нуун далдлахыг хүсэхгүй байна. . . . Бидний цаг үеийн хөл үймээнтэй хөгжлүүд нь биднийг хааш нь авч яваа талаар бараг бүх нийтийн болсон айдас болон бидний бүрэн гүйцэд ойлгох боломжгүй гоц үзэгдлийн талаарх гүн зовинолын мэдрэмжид хяналт тогтоох боломжгүй. Ирээдүйн төрхийн талаарх бүхий л эргэцүүллийн ихэнх нь гутран-

гуй, мөн сэтгэлийг минь гүн гүнзгий үймүүлсэн дорой байдал болон аминд халгаатай анхааруулга ахин дахин бодогддог. Энэ бол шинэ гоц үзэгдлүүд биш билээ. Хүний нийгмийн шилжилт ба өөрчлөлтийн үеүдэд ихэнхдээ айдас төрүүлэм бошиглолуудын шинж тэмдэг байжээ. Өсөн нэмэгдэж буй эдгээр айдсууд бүхий асуудлуудын шинэ далайц болоод цар хүрээ нь юу вэ. . . .

“ Өнөөдөр соёл иргэншил ийм маргаантай асуудлуудтай тулгарч байгаа нь хүн төрөлхтний нэгэн багаахан хэсэгт биш бүхий л хүн төрөлхтөнд тулгарч байна.” (United Nations General Assembly address, 30 Aug. 1974; italics added.)” (“Guidance of the Holy Spirit,” *Ensign*, Jan. 1980, p. 2.)

# Бошиглогчид, Үзмэрчид хийгээд Илчлэгчид Гэж Хэн бэ?

Бүлэг 2

## Заах Зорилго

Бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчид Бурханы хаант улсыг газар дэлхий дээр барихад чухал үүрэг гүйцэтгэдийг оюутнууд ойлгох ёстой.

## Товч Утгын Жишээ

- А. *Бошиглогч, үзмэрч* хийгээд *илчлэгч* гэсэн хэллэгүүд нь Бурхан эрэгтэйчүүдэд өгдөг онцгой сүнслэг бэлгүүдийг дүрсэлнэ.
- Б. Бурхан газар дэлхий дээр өөрийгөө төлөөлөх эдгээр бэлгүүд ба эрх мэдлүүдийг тэдэнд сонгож өгдөг.
- В. Сүмийн Ерөнхийлөгч газар дэлхий дээр эрэгтэйчүүд хэрэглэдэг эдгээр бэлгүүдийг удирддаг.
- Г. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулга нь бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчдийг баталдаг.

## Заах Зөвлөмжүүд

■ Дараах дасгалыг *бошиглогч, үзмэрч, илчлэгч* хийгээд *бошиглогчдын зөгнөл* гэсэн хэллэгүүдийн тухай оюутнууд юу ойлгосныг нь тодорхойлоход хэрэглэ. Оюутнуудыг ангидаа ирэхээс нь өмнө дасгалыг өсгөгч дээр болон самбарт бич. Оюутнуудыг дасгалаа дуусгахад нь тусалж мөн зүйл бүр нь та нарынхтай тохирч байгаа эсэхийг ярилц.

Эдгээр тодорхойлолтууд нь та нарыг оюутнуудтай дасгалын талаар ярилцахад тусалж магад.

*Бошиглогч* гэдэг нь Есүс бол Христ, Бурханы хүү гэдгийг Ариун Сүнсний тусламжтайгаар хувийн илчлэлтээр мэдсэн хүн юм (Илчлэлт 19:10-ыг үз; Bible dictionary, s.v. "prophet").

*Үзмэрч* гэдэг нь Их Эзэнээс илчлэлт хүлээн авч мөн тэрээр өөр хүний өмнөөс үнэнийг хүлээн авч дамжуулдаг хүн юм.

*Илчлэгч* гэдэг нь Урим ба Туммимыг хэрэглэхээр сонгогдож томилогдсон бошиглогч юм (Мозая 8:13; 28:13–16-г үз; Joseph Smith—History 1:35; Bible dictionary, s.v. "seer").

*Зөгнөл* гэдэг нь хэд хэдэн утгатай:

- 1. Бурхан өөрийн бошиглогчдоор дамжуулан өгсөн илчлэлтүүд нь зөгнөл юм (Үйлс 7:38; С ба Г 124:126-г үз).
- 2. Хүмүүсийн өмнөөс илчлэлт хүлээн авдаг эрэгтэйчүүд зөгнөгчид юм (1 Петр 4:11-ийг үз).

- 3. Зөгнөлүүд хүлээн авагддаг аливаа ариун нандин газар зөгнөл хэмээн нэрлэгддэг (Хаадын дээд 6:16; С ба Г 124:39 -ийг үз).

*Mormon Doctrine* дахь Ахлагч Брюс Р.МакКонкигийн тайлбарыг та нар мөн уншиж болно (2d ed. [Salt Lake City: Bookcraft, 1965–73], pp. 547, 605, 651, 700–701).

Дараахыг тохируул:

- а. Бошиглогч
- б. Үзмэрч
- в. Илчлэгч
- г. Зөгнөл
  - 1. (г) Бурханаас ирдэг илчлэлт
  - 2. (б) Ердийн нүдээр харагдахгүй зүйлсийг харж чадна
  - 3. (а) Их Эзэний төлөөний хүн
  - 4. (а) Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг мэддэг хүн (Илчлэлт 19:10-ыг үз).
  - 5. (г) Ариун Сүм
  - 6. (б) Өнгөрсөн, одоо, ирээдүйн зүйлсийг мэдэж чадна
  - 7. (г) Бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчид
  - 8. (в) Мэдэгдэхгүй байгаа ямар нэг юмыг Их Эзэний тусламжтайгаар мэдүүлдэг
  - 9. (а) Мосе Бурханы бүх хүмүүсийг үүн шиг байхыг хүсдэг байлаа (Тооллого 11:29-г үз)
  - 10. (б) Урим ба Туммимийг хэрэглэх эрхтэй (эсвэл хөрвүүлэгчид)
  - 11. Хүн (б) гүйгээр (а) байж болно, гэвч (б) нь мөн (а) юм.

Энэ дасгалд хэтэрхий их тодорхой байх хэрэггүй. Эдгээр нэр томъёонуудыг хэрэглэх ба тодорлоход зарим нэгэн давхцал байдаг. Жишээ нь, зөгнөл гэдэг нь бүх хэсэгт тохирч байна. Энэ дасгалын зорилго нь оюутнуудад нэр томъёонуудын ерөнхий ялгааг ойлгоход туслах явдал юм.

■ Оюутнуудыг Сүмийн одоогийн бошиглогчид, үзмэрчид ба илчлэгчдээс суралцахыг урамшуул. Энэ хичээлийг сурсан оюутан бүр Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн гишүүдийн нэрсийг мэдэх ёстой бөгөөд тэдний хүн бүрийг таньдаг болох ёстой. Сүмд залгамжлал дагадаг зарчмууд байдаг тул оюутнууд Төлөөлөгчдийг насны ахмадаар нь бас мэдэх ёстой.



---

Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн зурагнууд нь товч намтрын хураангуйн хамт Амьд Бошиглогчдын Сургаалууд боодолд өгдөг, худалдааны дугаар нь PMSI1169. Эдгээр зурагнуудыг анги дахь ярилцлаганд мөн зарлалын самбар зэрэгт оюутнуудад харагдахаар тавьж ашиглаж болно.

- Оюутны гарын авлаганы дугаар 4 -ийн 2-7 дахь асуултуудыг ярилц.

- Оюутны гарын авлагын 2-6 дахь диаграмм ашиглан бошиглогчид, үзмэрчид хийгээд илчлэгчдийн үлдсэн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хоорондох хамаарлуудыг үзүүлэн таниул. Тус хэсэг дэх бага Ж.Рюбэн Кларкын мэдэгдлийг ярилц. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчид хаант улсын сургаалыг заах онцгой дуудлагатай болохыг оюутнуудыг олж мэдэхэд тусал.

## Заах Зорилго

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгч нь бүх дэлхийн бошиглогч гэдгийг оюутнууд мэддэг байх ёстой.

## Товч Утгын Жишээ

- А. Жишиг бүтээлүүд нь Бурхан цаг хугацааны эхлэлээс авахуулаад өөрийн оюун ухаан болон хүслийг амьд бошиглогчдод илчилж ирснийг гэрчилдэг.
- Б. Сүмийн бүх удирдагчид Сүмийн Ерөнхийлөгчийн эрх мэдэл ба удирдлага дор үүрэг гүйцэтгэдэг.
- В. Их Эзэн өөрийн бошиглогч нь Сүмийг буруу замаар удирдахыг хэзээ ч зөвшөөрдөггүй.

## Заах Зөвлөмжүүд

- Сүм зохион байгуулагдсан өдөр Их Эзэн бошиглогчдын тухай юу гэж хэлсэн талаар оюутнуудтай ярилц (С ба Г 21:4–6-г үз).
- Оюутны гарын авлагын 3-2 дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны мэдэгдэл үнэн болох талаар ярилц. Яагаад ихэнхдээ өмнөх бошиглогчид хүндлэгдэж байхад амьд бошиглогчид анзаарагддаггүйг оюутнуудаас асуу. Энд зарим болзошгүй шалтгаанууд байдаг:
  1. Өмнөх бошиглогчид бусдад тэдний бүтэлгүйтлийг хэлж юу хийхийг нь хэлдэг байсан. Наманчлахын тулд бид юу хийх ёстойг амьд бошиглогчид бидэнд хэлдэг.
  2. Урьд байсан бошиглогчдын үгс нь цаг хугацаа болон нөхцөл байдлаар үнэн нь нотлогдсон байдаг.
  3. Амьд бошиглогчид биднээс заримдаа хэцүү зүйлийг, бидний хувьд сэтгэл ханамжтай байдаг алдартай хөгжим, загварын хувцас болон мэдээллийн хэрэгсэл зэрэг зүйлүүдийг хийхгүй байхыг хүсдэг.

Дараах нөхцөл байдлуудыг танилцуулж юу нь буруу болохыг өөртөө хэлэхийг оюутнуудаас хүс:

1. Сүмийн гишүүн илчлэлтийг ерөнхий чуулган дээр мэдэгдэхийг хүссэн бөгөөд тэр хэлэхдээ Их Эзэн ирээдүйн аюулд бэлтгэх талаар мэдэгдсэн гэж хэлжээ.
2. Нэг хүн археологийн малталтаас өөрийн олсон зарим баримт дээр тулгуурлан Агуу Үнэт Сувдад залруулга оруулах тухай мэдэгджээ.
3. Нэг хүн бошиглогч эсвэл түүний урьд байгсдын ярьсан маргаантай асуудлын талаар ном

бичээд үүнийгээ сүмийн албан ёсны сургаал гэж нэрлэжээ.

4. Сүмийн алслагдмал бүсэд нэг гишүүн эмэгтэйчүүдийг санваартнаар маш тодорхой сонгогдсон шалгуураар баталж эхэлсэн байна.

Сүм дэх харилцааны албан ёсны шугам болон Сүмийн Ерөнхийлөгчөөс чухал илчлэлтүүд буюу бодлогыг гишүүдэд хүргэдэг арга замын тухай ярилц. Оюутны гарын авлагын 3-5 дахь материалыг ашигла.

- Амьд бошиглогчийн үүргийг заахын тулд нэг сэдэвт цуврал судруудыг ашигла. Ижил сэдэвт дараах цуврал судар нь бошиглогч Мосе шиг амьд бошиглогчийн талаар өгүүлдэг. Мосе 1:3, 6; Сургаал ба Гэрээ 28:2; 107:91–92.

Өнөөдрийн Сүмийн Ерөнхийлөгч ямар байх талаарх үлгэр жишээг Мосе хэрхэн өгсөн тухай ярилц. Дараах диаграммыг самбарт байрлуулж тэдний ижил төстэй талуудыг дүрсэл:

<i>Мосе</i>	<i>Амьд Бошиглогч</i>
1. Израилыг удирдахын тулд илчлэлт хүлээн авсан.	1. Өнөөдөр сүмийг удирдахын тулд илчлэлт хүлээн авдаг.
2. Израилыг боолчлолоос гаргахад удирдсан.	2. Сүмийг сүнслэг боолчлолоос гаргахаар удирддаг.
3. Израилыг адислахын тулд санваарын түлхүүрүүдийг атгадаг байв.	3. Сүмийн гишүүдийг адислахын тулд санваарын түлхүүрүүдийг атгадаг.

- Дараах судруудыг оюутнууд уншиж, тэмдэглэж, тайлбар хавсаргахаар даалга.

Даалгаврыг хийсний дараа тэдний сурсан зүйлийн тухай ярилц.

*Сургаал ба Гэрээ 1:14–16.* Хэрэв бид бошиглогчдыг анхаарахгүй бол бид тусгаарлагдах болно.

*Сургаал ба Гэрээ 1:38.* Их Эзэний дуу хоолой байна уу, эсвэл түүний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу ялгаагүй, энэ нь адил юм.

*Сургаал ба Гэрээ 50:36.* Бошиглогчийн үгсийг сондог тэд адислагдсан болой.

*Сургаал ба Гэрээ 52:9.* Бошиглогчдын бичсэнийг заа.

*Сургаал ба Гэрээ 84:36.* Их Эзэний үйлчлэгчдийг хүлээн авна гэдэг нь түүнийг хүлээн авна гэсэн үг.

*Сургаал ба Гэрээ 90:5.* “Тэдгээр нь хөнгөмсөг зүйлд тооцогдохгүйн тулд” зөгнөлүүдийг өргөж яв.

Сургаал ба Гэрээ 124:45–46. Хэрэв бид бошиглогчдыг дагавал, бид адислагдах болно.

Сургаал ба Гэрээ 133:71. Хэрэв бид Их Эзэний үйлчлэгчдэд итгэхгүй бол, бид аврагдахгүй байх болно.

2 Нифай 26:3. Бошиглогчдыг зайлуулах тэд мөхөх болно.

Мозая 18:18–19. Зөвхөн бошиглогчдоор яригдсан зүйлүүдийг заахыг Алма санваартнуудад зарлиглажээ.

3 Нифай 28:34–35. Бошиглогчдыг хүлээн авдаггүй тэд Аврагчийг хүлээн авдаггүй.

Амос 3:7. Бурхан өөрийн нууцуудыг бошиглогчоор дамжуулан илчилдэг.

■ Исаиа 55:8–9 ба Амос 3:7-г оюутны гарын авлагын 3-7-дахь хэлсэн үгнүүдтэй хамт ашиглан бошиглогчоос ирсэн тодорхой заавруудын шалтгаануудыг хэдийгээр бид мэдэхгүй байж болох ч гэсэн, бид бүх зүйлд түүнийг дагаж, Их Эзэнээс баталгаа хайх ёстой. Бошиглогчийг дагах нь биднийг Бурхантай үргэлж ойр байхад хүргэх болно. Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн дараах мэдэгдлийг ярилцаад, Бурханы зарлигууд нь ямагт түүний бошиглогчдоор ирэх болно гэдгийг цохон тэмдэглэ.

“Аз жаргал нь бидний оршихуйн зорилго, утга учир билээ. Бурханы бүхий л зарлигуудыг дагаж

хэрэв бид үүнд хүргэдэг замаар замнавал энэ нь ариун журмын, үнэнч шударгын итгэлийн, ариун байдлын зам юм. Эцсийн эцэст бид аз жаргалд хүрэх болно. Гэхдээ эхэндээ мэдээгүй байж бид бүхий л зарлигуудыг дагаж чадахгүй бөгөөд мөн урьд нь аль хэдийнээ хүлээн авсан тэдгээрийг мөрдөж дагалгүйгээр бид одоо илүүг сурч бүгдийг нь мэдэхээр найдаж чадахгүй. Нэг нөхцөл байдалд буруу зүйл магадгүй ихэнхдээ ийм байж болох ч, өөр нөхцөлд зөв байх нь олонтаа байдаг.

“Бурхан ‘Чи хүн бүү ал’ гэж хэлсэн бөгөөд өөр нэгэн үед Тэр ‘Чи бүрмөсөн устга’ гэж хэлсэн байдаг. Энэ нь хаант улсын хүүхдүүд хаана байгаагаас нөхцөл байдалд нь тохируулсан илчлэлтээр удирдагддаг тэнгэрийн засаглалын зарчим. Хэдийгээр бид шалтгааныг нь үйл явдал урт хугацааны дараа болохоос нааш олж харахгүй ч гэсэн, юу байсан ч хамаагүй Бурханы шаардсан бүхэн нь зөв юм. Харин эхлээд Бурханы хаанчлал болон зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно.” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [Salt Lake City: Deseret Book Co., 1938], pp. 255–56.)

■ “Бошиглогчийг Дагах Арван Дөрвөн Гол Зарчим”-ыг (оюутны гарын авлага 3-8-ыг үз) дахин давтаж мөн тэдгээр нь үнэн болохыг гэрчил. Бид Их Эзэний бошиглогчийг асуудал бүр дээр дэмжих нь амин чухал болохыг онцлон тэмдэглэ.

### Заах Зорилго


Амьд бошиглогч нь жишиг бүтээлүүдтэй холбоотой онцлог үүрэгтэй гэдгийг оюутнууд суралцах ёстой.

### Товч Утгын Жишээ

- А. Бүхий л зааврууд нь Ариун Сүнсээр нөлөөлөгддөг болохыг *Судар* хэлж өгдөг (С ба Г 68:2-4-ийг үз).
- Б. Жишиг бүтээлүүд болох судрууд нь Сүмээр хүлээн зөвшөөрөгдөж, батлагдсан байдаг.
- В. Амьд бошиглогчид Гэгээнтнүүдийг удирдах нэмэлт судраар хангаж өгдөг.
- Г. Сүмийн гишүүн бүр, Бошиглогч Сүмийг зөвөөр удирддаг гэдгийг өөрийн биеэр мэдэж болно.

### Заах Зөвлөмжүүд

- Судар гэж юу вэ? Оюутнуудад энэ асуултанд хариулах боломж олго. Тэгээд Сургаал ба Гэрээний 68:2-4-ийг уншиж ярилц.
- Самбарт дараах үзүүлэн таниулах материалыг зурж, үүнийгээ ярилцахад ашигла.



- Дараах асуултуудыг асууж болно:
  1. Яагаад жишиг бүтээлүүдийг батлагдсан, хүлээн зөвшөөрөгдсөн гэж нэрлэдэг вэ? (оюутны гарын авлагын 4-1-ийг үз). Самбарт *жишиг бүтээлүүд* гэж бичин утгыг нь ярилц. Жишиг бүтээлүүд нь судар болохыг, гэвч бүх судрууд жишиг бүтээлүүдийн хэсэг биш болохыг ойлгоход нь оюутнуудад тусал.
  2. Судруудыг тайлбарлах нь хэний онцгой эрх байдаг вэ? (2 Петр 1:21; оюутны гарын авлагын 4-2-ыг үз).
  3. Үг хэлэгчид Ариун Сүнсээр урагш хөдөлгөж байгааг, мөн тэдний хэлж байгаа зүйл

судар гэдгийг бид яаж мэдэх вэ? (оюутны гарын авлагын 4-6-г үз).

- Оюутны гарын авлагын бүлэг 4-ийг давтахад нөхцөлийн жишээ судалгааг доорх байдлаар хөгжүүлж болох юм.
  1. Сургаал ба Гэрээнээс хойш яагаад өөр судар байхгүй байгааг Жон, Мэри нар ойлгодоггүй ажээ. Та тэдэнд хэрхэн хариулах вэ?
  2. Жишиг бүтээлүүдэд энэ нь байхгүй байгаа учраас Жим хувийн илчлэлтийг хүлээн зөвшөөрөхөд бэрхшээлтэй байв. Үүнийг хүлээн зөвшөөрөхөд нь та түүнд хэрхэн тусалж чадах вэ?
- Хүмүүсийн сүнслэг бэлэн байдлаас нь хамааруулж Их Эзэн хуулиуд, зарлигууд, зааврууд өгч мөн буцаан авч байсан жишээнүүдийг жагсааснаар оюутнуудыг одоогийн судрын чухлыг ойлгоход нь тусал. Зарим жишээнүүд оюутны гарын авлагын 4-3-аас олдоно. Энэ нь Бурхан өөрчлөгдөж байдаг, эсвэл тэр тогтворгүй гэсэн үг биш гэдгийг онцол. Энэ нь бидний нөхцөл байдал, бэрхшээлүүд болон сүнслэг бэлэн байдалд тэр мэдрэмтгий болохыг харуулж байна.

Дараах төсөөтэй байдлуудыг ашиглан энэхүү ерөнхий адил төстэй байдлыг ойлгоход нь тусал:

1. Бид нялх хүүхдэд сүү мөн хоол тэжээл өгдөг. Түүнийг өсөх тусам тэр насанд хүрэгчдийн илдэг хоолыг идэх хүртэл бид илүү найрлагатай хоол өгдөг. Энэ үйл явцад хүнс тэжээл ба өсөлтийн хуулиуд өөрчлөгддөггүй. Тэдгээр нь хүүхдийн янз бүрийн үеүдийн нөхцөл байдалд хамаатай байдаг.
2. Оюутанд тоо, тоо тоолох, Арифметик, Алгебр, тригонометр, тооцоо заадаг. Энэ дэс дарааллыг өөрчилж болохгүй, тэгвэл оюутнууд тооцоог ойлгохгүй байх болно. Хэрэв оюутнуудад маш хурдан заавал ойлгохгүй, гол ойлголтуудыг ухаж мэдэхгүй, багш “эргэж” оюутнуудын сул мэдсэн зүйлс дээр нь туслах ёстой.

Төстэй байдлууд тус бүр нь оролцогчдын хэрэгцээ ба бэлэн байдалд хамаатай байж эсвэл буцаан авсан хуулиуд болон заавруудын дагуу байна. Иймээс энэ нь Бурханы хаант улсад байдаг зүйл.

- Хэрэв бошиглогч хүмүүсийн судруудын тайлбаруудыг батлаагүй эсвэл өөр цаг үе нөхцөл байдалд өгөгдсөн тохиолдолд хэн нэгэн судруудыг хүлээн авагч төөрөгдөлд орж гэхдээ бошиглогчийг дагахыг татгалзсан болохыг ярилц.

Бүхий л асуудлуудад бошиглогчийн зөвлөгөө жишээг хайж дагаснаар маш их найдвартай байдалд байдаг талаар онцол. Оюутны гарын авлага 4-8-д байгаа энэ сэдвээр ерөнхийлөгч Вилфорд Вудрафф ба Ахлагч Жон А.Видцое нарын ухаалаг зөвлөгөөг ярилц.

Оюутны гарын авлагын 4-4-ийн хэлсэн үгнүүдийг оюутнуудаар тайлагнуул.

### Заах Зорилго

Оюутнууд Тэргүүн Зөвлөлийн эрх мэдлийн цар хүрээ гол үүрэг зорилгуудыг ойлгох ёстой.

### Товч Утгын Жишээ

- А. Тэргүүн Зөвлөл Сүмийн бүх ажил хэргийг тэргүүлдэг.
- Б. Тэргүүн Зөвлөл Сүмийн сургаалыг тайлбарлах онцгой эрхтэй.
- В. Тэргүүн Зөвлөл Сүмийг удирдах илчлэлтийг үргэлж хүлээн авдаг.

### Заах Зөвлөмжүүд

■ Тэргүүн Зөвлөлийн дараах үйл ажиллагаанууд болон онцгой эрхүүдийг самбарт, проекцийн аппаратын тунгалаг ялтсан дээр, эсвэл тарааж өгөх материалд жагсааж оюутан бүрт тарааж өг. Эдгээр хэлсэн үгнүүдэд Сүм дэх санваартны чуулгын аль нь дүрслэгдснийг оюутнуудаас асуу.

1. Дэлхий дээрх Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг
2. Сүм дэх бүхий л албан тушаалуудад албан үүрэг гүйцэтгэнэ
3. Сүм дэх бүх зөвлөлүүд, чуулгууд болон байгууллагуудыг тэргүүлдэг
4. Сүм дэх хамгийн дээд томилох хүч болон нэр дэвшүүлэх хүчтэй байдаг
5. Сүм дэх хамгийн дээд зөвлөл юм
6. Сүм дэх хуулийн хамгийн дээд шүүгч бөгөөд тайлбарлагч мөн
7. Сүнслэг асуудлуудлаарх шийдвэрүүдийн хувьд эцсийн эрх мэдэл эдэлдэг
8. Сүмийн бүх ажлын талаар эрх мэдэл эдэлдэг
9. Сүм дэх хамгийн дээд удирдах хүчтэй байдаг
10. Сүм дэх захиргааны холбогдолтой бүх асуудлыг чиглүүлдэг
11. Сүмд зориулж сургаалыг тайлбарладаг

Эдгээр бүх асуудлууд Тэргүүн Зөвлөлд хамаардгийг оюутнууд түргэн ойлгох болно. (Оюутны гарын авлагын бүлэг 5-д нэмэлт мэдэгдлүүд болон судрын лавлагаанууд өгөгдсөн байгаа.) Үнэндээ, Их

Эзэнээс Тэргүүн Зөвлөлд өгөгдсөн өргөн үүрэг хариуцлага, эрх мэдлийг онцлох нь энэхүү дагсгалын зорилго юм. Хэлсэн үг бүрийн утгыг ярилцаж тэдгээрт хэрхэн хамаатай байгаа жишээнүүдийг гарга. Оюутны гарын авлагын 5-2 дахь Ерөнхийлөгч Н.Элдон Таннерын хэлсэн үгнээс жишээ болгон хэдийг авч болох юм.

■ Дараах судруудыг оюутнуудаар тэмдэглүүлж, харьцуулах ишлэлүүдийг хийлгэ. Тэргүүн Зөвлөлийн үүрэг хариуцлагуудыг товчид нь эдгээр шүлгүүдэд гаргасныг ярилц.

*Сургаал ба Гэрээ 81:2.* Тэргүүн Зөвлөл Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг.

*Сургаал ба Гэрээ 90:12-16, 32.* Тэргүүн Зөвлөл Сүмийг тэргүүлж, хаант улсын нууцуудыг ил болгохын тулд илчлэлтийг хүлээн авч, Сүмийн ажил хэргүүдийг эмх журамд зохион байгуулдаг.

*Сургаал ба Гэрээ 107:8-9, 22, 78-80.* Тэргүүн Зөвлөл Сүм дэх бүх албан тушаалуудад ажил үүрэг гүйцэтгэх эрхтэй бөгөөд эцсийн давж заалдах шүүх болох чуулгыг эмхлэн байгуулдаг.

*Сургаал ба Гэрээ 124:126.* Тэргүүн Зөвлөл Сүмд зориулсан илчлэлтийг хүлээн авдаг.

■ Сургаал ба Гэрээ 112:19-20 уншиж ярилц. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн хоорондын харилцааг ойлгоход нь оюутнуудад тусал. Шүлэг 19 нь Тэргүүн Зөвлөл тэднийг хаа илгээсэн газарт Арванхоёр явах ёстойг таниулж, харин Шүлэг 20 нь Арванхоёр нь Тэргүүн Зөвлөлөөс зөвлөгөө чиглэл хүлээн авдгийг нотолдог.

■ Оюутны гарын авлага дугаар 3-ын 5-7-д өгөгдсөн хоёр албан тушаалыг ярилц. Тэнд Ахлагч Марион Ж.Ромни зааврууд өгсөн талаар ярилц. Их Эзэний сүнсээр удирдагддаг хүн яагаад Тэргүүн Зөвлөлтэй зохицолтой байхаас гадуур байдаггүй вэ? Хэрэв хүн Тэргүүн Зөвлөлтэй зохицолтой байхгүй бол түүний үүрэг хариуцлага юу байх вэ?

■ Бурханы сонгосон хүмүүсийн нэг нь хэрхэн урвалтанд орж болох талаар ярилц. Хүн урвалтаас чөлөөтэй байж чадна гэж боддог эсэхийг нь оюутнуудаас асуу. Хүн байнга сонор сэрэмжтэй байгаагүйгээсээ болж сайн мэдээний адислалуудаа алдаж болохыг ойлгоход нь тусал. Их Эзэний сүм дэх гишүүнчлэлээ хэзээ ч алдахгүй багтай байхад тэд юу хийж болохыг оюутнуудаас асуу. Урвалтаас зайлсхийх арга замуудыг ярилцсаны дараа оюутны гарын авлагын 5-6 дахь ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, Ахлагч Марк И.Петерсэний хэлсэн үгийг ярилц.

### Заах Зорилго

Бүх дэлхийд бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид болсон Их Эзэний онцгой гэрчүүд болдог Төлөөлөгчдийн талаар оюутнууд суралцах ёстой.

### Товч Утгын Жишээ

- Христийн Сүмийн тэмдгүүдийн нэг нь Төлөөлөгчид ба бошиглогчидтой байх явдал юм.
- Төлөөлөгчид нь Сүмийг эмх цэгцэнд оруулж, сургаж, сайн мэдээг тодорхой болгож өгдөг.
- Арванхоёрын Чуулга нь Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг.

### Заах Зөвлөмжүүд

■ Ерөнхийлөгч Харолд Б.Лигийн ярьсан дараах нөхцөл байдлыг танилцуулж энэ нь тэдэнд тохиолдвол тэд юу хийхийг оюутнуудаасаа асуу. (Үйлс 1:21–22 дахь тохинуулагчийн үйл явдлын талаар ярь.)

“Хэдэн жилийн өмнө хоёр номлогч тэдэнд маш хэцүү асуулт байсан зүйлийн талаар надад хандан ирсэн юм. Үнэн сүм газар дэлхий дээр өнөөдөр оршиход төлөөлөгчид зайлшгүй хэрэгтэй гэж тэднийг хэлэхэд нэгэн залуу Методист пастор тэднийг шоолон инээсэн ажээ. ‘Сул гарсан орон тоог бөглөх хүнийг сонгохын тулд төлөөлөгчид цугласан нь Иудасын үхлээр шалтгаалагдсаныг та нар мэднэ биз дээ гэж тэр тохинуулагч хэлснийг тэд өгүүлээд, энэ бол тэдэнтэй хамтрагч байж, Их Эзэний үүрэг зорилго хийгээд амилалтанд хамаатай бүх зүйлүүдийн гэрч байсан биз дээ? Хэрэв тэр нь төлөөлөгчийн хэмжүүр байх юм бол та нарт төлөөлөгчид байдаг гэж та нар яаж хэлж чадна вэ?’ гэж тэр хэлсэн хэмээн тэд өгүүлсэн ажээ.

“Тэгээд тэдгээр залуу эрчүүд, ‘Бид юу гэж хариулах вэ?’ гэсэн юм” (*Stand Ye in Holy Places* [Salt Lake City: Deseret Book Co., 1974], p. 64.)

Оюутнууддаа хариулах цаг гаргасны дараа, Ерөнхийлөгч Лигийн хариултыг тэдэнтэй хуваалц:

“Би тэдэнд хэлэхдээ ‘Буцаж очоод өөрсдийн найз пастороос хоёр асуултыг асуу. Нэгдүгээрт, Төлөөлөгчөөр дуудагдахад зайлшгүй шаардлагатай зүйлийг Төлөөлөгч Паул хэрхэн олж авсан бэ? Тэр Их Эзэнийг мэддэггүй, биечлэн таньдаггүй байсан. Тэр төлөөлөгчдийг дагалдан явдаггүй байсан. Тэр тохинууллын төдийгүй Их Эзэний амилалтын ч гэрч байгаагүй билээ. Төлөөлөгч байх хангалттай гэрчлэлийг тэр яаж олж авсан бэ? Түүнээс асуух хоёр дахь асуулт, Өнөөдөр байгаа бүх төлөөлөгчид

үүнтэй адилаар тэрхүү гэрчлэлийг олж аваагүйг тэр яаж мэддэг вэ?’

“Төлөөлөгчдийн дуудлагыг атгадаг хүмүүс Их Эзэний үүрэг зорилгын бодит байдлыг хэрэгжүүлдэг, мөн мэддэг гэдгийг би та нарт гэрчилж байна.” (*Stand Ye in Holy Places*, p.65.)

■ Оюутны гарын авлагын 6-2 дахь Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит, Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит болон Ахлагч Бойд К.Пакер нарын төлөөлөгчдийн дуудлага нь онцгой гэрч нар гэсэн хэлсэн үгнүүдийг ашиглан ярилц. Оюутны гарын авлагын 6-2 дахь сүүлийн ишлэлд байгаа Жозеф Фийлдинг Смитийн дүрсэлсэн сүнсний хүчирхэг гэрчийг олоход оюутнуудад тусал.

Доорх хоёр гол зүйлийн улмаас Арванхоёр Төлөөлөгч бол Христийн онцгой гэрчүүд гэдгийг онцлон тэмдэглэ.

- Тэдний хүлээн авсан гэрчлэлийн хүч болон баттай байдал.
- Тэд бол гэрчүүд бөгөөд бүх үндэстнүүдэд сайн мэдээг зайлшгүй хүргэх түлхүүрүүдийн бүрэн байдлыг атгадаг тэрхүү баримт. (Joseph Fielding Smith, *Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [Salt Lake City: Bookcraft, 1954–56], 3:146; С ба Г 107:23, 33, 35-ыг үз).

■ Сүмд Төлөөлөгчид ба Бошиглогчид нь хэр чухал байдаг вэ? (Ефес 2:19–20-ыг үз.) “Төлөөлөгчид болон бошиглогчид нь Их Эзэний хүслийг Сүмд биелүүлэгч илчлэгчид учраас илчлэгдсэн шашин нь үүсэн байгуулагдахад бүхий л бүтэц нь үндэслэгдсэн байдаг. Төлөөлөгчид ба бошиглогчид нь Их Эзэнээс илчлэлт хүлээн авдаггүй мөн Бурханы хаант улсын түлхүүрүүдийг газар дэлхий дээр атгадаггүй байвал энэ нь Их Эзэний Сүм биш юм.” (Bruce R. McConkie, *Doctrinal New Testament Commentary*, 3 vols. [Salt Lake City: Bookcraft, 1965–73], 2:504.)

Бидэнд Төлөөлөгчид ба бошиглогчид хэр зэрэг удаан хугацаанд хэрэгтэй байх вэ? (Ефес 4:11–14-ийг үз).

■ Ефес 2:19–20, 1 Коринт 12:28 мөн Илчлэлт 19:10-ыг оюутнуудаар иш татуул. Тэднээс Их Эзэн яагаад Сүмдээ эхлээд Төлөөлөгчдийг хоёрдугаар бошиглогчдыг тавьсныг асуу. Ахлагч Вилфорд Вудрафф дараах ишлэл энэ асуултыг хариулахад туслах болно:

“Би бол бошиглогч. Та нар ч мөн бошиглогчид. Есүс Христийн гэрчлэлтэй хэн ч гэсэн бошиглогч билээ, ийм л зүйлд бошиглолын сүнс байдаг. Израйлын Ахлагчид ч бошиглогчид юм. Бошиглогч нь Төлөөлөгч шиг тийм агуу байдаггүй. Христ өөрийн Сүмдээ нэгдүгээрт, Төлөөлөгчдийг дуудан тавьж, тэд Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атгадаг.” (In *Journal of Discourses*, 13:165.)

---

■ Ефес 2:19–20-ыг оюутнуудтай Их Эзэн хэрхэн Төлөөлөгчдийг (тэдгээр нь бошиглогчид) Сүмд өсөлт хөгжилт, нэгдмэл байдал хуурамч сургаалыг ил гаргахад ашигласан болохыг шинжлэн бод. Үйлс 15:1–31, оюутны гарын авлагын 6-6-гийн Ахлагч Марк И.Петерсэн, Ахлагч Спенсер В.Кимбалл нарын хэлсэн үгнүүдийг ярилц. Гэгээнтнүүдийн сургаалыг залруулан сургаалын нилээд ярвигтай асуудлуудаар тэдэнд анхааруулга өгч байгаа орчин үеийн төлөөлөгчдийн зарим

жишээг ярилц. Хэдийгээр Төлөөлөгчид залруулан, эмх цэгцэд оруулдаг ч гэсэн энэ нь төлөвшсөн сургаал хийгээд бодлогын хүрээнд байдгийг оюутнууд баттай ойлгоход анхаар. Төлөөлөгчид нь үнэн хэрэгтээ Сүмд шинэ сургаалыг тунхагладаггүй мөн бошиглогч эсвэл Тэргүүн Зөвлөлөөр батлагдсан зүйлс эсвэл Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын Төлөөлөгчдийн хамтын дуу хоолойноос гадуур судруудыг тайлбарладаггүй билээ.

### Заах Зорилго

Залгамжлалын зарчмууд нь Сүмийн шинэ Ерөнхийлөгчийг дуудах болон дэмжүүлэн батлахтай холбогдон тодорхой үндэслэгдсэн байдгийг оюутнууд ойлгох ёстой.

### Товч Утгын Жишээ

- А. Их Эзэн хэн Сүмийн Ерөнхийлөгч байхыг төдийгүй залгамжлалд үндэслэгдсэн байхыг мэддэг.
- Б. Төлөөлөгч бүр илчлэлтээр дуудагдаж, Бурханы хаант улсын түлхүүрүүдийг атган Ерөнхийлөгчийн удирдлаган дор байдаг.
- В. Сүмийн Ерөнхийлөгч нас барах үед Тэргүүн Зөвлөл тардаг. Арванхоёрын Чуулга нь удирдах чуулга болдог.
- Г. Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч, хамгийн ахмад Төлөөлөгч нь Сүмийн шинэ тэргүүлэх ажилтан болдог.
- Д. Сүмийн гишүүд нь шинэ Ерөнхийлөгчийг онцгой хуралдаанаар сонгох боломжтой байдаг.

### Заах Зөвлөмжүүд

- Дараах нөхцөл байдлыг танилцуул:

“Та нар 1844 оны зун Навууд амьдарч байна гэж төсөөл. Бошиглогч Иосеф Картажид хэдэн сарын өмнө алуулж нас барлаа. Хямрал боллоо. Хожмын Уеийн Гэгээнтнүүд хоньчингүй хонин сүрэг мэт байна. Тэдний маш олон нь хэн Сүмийг удирдах талаар баттай бусаар санаа зовж байна. Иосефийг хэн нэгэн залгамжлахад Их Эзэн ямар нэгэн бэлтгэл хийсэн үү?

“Иосеф Смит Сүмийн тэргүүн Ерөнхийлөгч нас барлаа. Ерөнхийлөгчийн залгамжлал хэрхэн тохиолдохыг хэн ч урьд нь та нарт тайлбарлаагүй байна. Хүсч байгаа өрсөлдөгчид Бригам Янг болон Арванхоёрын чадлыг үзэхийг хүсэж байсан ч та нар тэдний шаардлагыг ойлгохгүй байна. Та нарт зөв удирдагчийг дагахдаа баттай байх өөр арга зам байна уу? Хэрэв та нар буруу удирдагчийг дагавал урвалтанд орж сайн мэдээний адислалуудыг алдах болно. Та нарт баримтлах өмнөх жишээ байсангүй, хямрал гэнэт гарч ирлээ.

“Та нар Навуу дахь цуглаанд оролцохоор дуудагдаа. Одоо Сидней Ригдон ярьж байна. Түүнийг дууссаны дараа Бригам Янг босоод зөвхөн хэдхэн минут ярих болно. Түүнийг ярьж байх үед, Ариун Сүнс түүнийг Сүмийг удирдахыг илчлэх болно. Энэ нь та нарын онцгой боломж байх уу? Та нар мэдэх үү? Удирдагчдын зөвлөгөөг урьд нь дагаж байсан уу? Тэгсэн бол одоо энэ нь та нарт тохиромжтой байх болно. Сүнсний өдөөлтүүд та нарт хүрч удирдахаар та тийм цэвэр ариун уу? Та нар эрх мэдэлтний дуу хоолойг таньж мэдэх нэгэн байх уу? Цуглаанаас явахдаа Бригам Янг бол цаг үе болон ирэх улиралд урьдчилан Их Эзэний тослогдсон хүн гэдгийг гэрчлэх үү?” (*Come unto Christ [Melchizedek Priesthood study guide, 1984], p 133.*)

- Оюутнуудад Сургаал ба Гэрээний 45:57-г уншиж өгч, энд орших захиасыг заа.

- Залгамжлалын зарчмуудыг жагсаахыг оюутнуудаас хүс. Оюутны гарын авлагын 7-4-т жагсаасан үе шат бүрийг тэд ойлгосон байхыг анхаар.

- Дараах судруудыг ярилцаж мөн тэмдэглэ:

*Сургаал ба Гэрээ 107:22–24.* Арванхоёрын Төлөөлөгчид нь чуулга байдлаараа Тэргүүн Зөвлөлтэй эн тэнцүү эрх мэдэлтэй.

*Сургаал ба Гэрээ 107:33.* Арванхоёрын Чуулга Сүмийн хэрэг явдлуудыг бүх үндэстнүүдэд байгуулах мөн зохицуулах түлхүүрүүдийг атгадаг.

*Сургаал ба Гэрээ 107:35.* Арванхоёрын Чуулга нь номлолын ажлын түлхүүрийг атгадаг.

Эдгээр судрууд залгамжлалын зарчмуудыг ойлгоход бидэнд хэрхэн тусалдаг вэ? (оюутны гарын авлага 7-1-ийг үз).

- Шинэ Ерөнхийлөгч дэмжин батлагдаж байгаа онцгой хуралдааныг үзүүлэхээр сонгож авсан видео хуурцаг байгаа бол та үзүүлж, шинэ Ерөнхийлөгчийг дэмжих журмыг ярилцаж болно.

- Оюутны гарын авлагын 7-6 дахь Ерөнхийлөгч Н.Элдон Таннерийн дүрсэлсэн шинэ Ерөнхийлөгчийг дэмжих журмыг ярилц.

- Онцгой хуралдааны үед Табернэклд байсан эсэхийг нь оюутнуудаас асуу. Хэрэв тийм бол ямар журмууд дэс дараалан явагдсан болон сэтгэгдлийг нь тэднээр яриул.



# Зөв Үзэл Баримтлал: Худал Хуурмагийн Эсрэг Хамгаалалт

Бүлэг 8

## Заах Зорилго

Мөнх бус ба мөнхийн хэтийн төлвийн хоорондох ялгааг ойлгосон хүн үнэнийг алдаанаас илүү сайн шүүх боломжтой гэдгийг оюутнууд ойлгох ёстой.

## Товч Утгын Жишээ

- Мөнх бус байдлын хэтийн төлвийн үнэнийг шүүх үндсэн арга болгон хүний мэдлэг болон шалтгааныг ашигладаг.
- Мөнхийн хэтийн төлөв нь бүхий л үнэнийг олсон хэмжүүрээр илчлэлтийг хүлээн авдаг тулгуурладаг.
- Өөрсдийн шийдвэрүүдийг Бурханы илчлэгдсэн үгэн дээр суурилуулдаг хүмүүс нь залилуулахаас зайлсхийх болно.

## Заах Зөвлөмжүүд

- Бурханы хэтийн төлөв ба хүний хэтийн төлвийн (оюутны гарын авлага хуудас 39-ийг үз) хоорондын харилцааг самбарт үзүүлэн диаграмм зур. Оюутнуудаар Исаиа 55:8–9-ийг уншуулж, эдгээр шүлгүүд диаграммтай хэрхэн холбогдож байгааг тэднээс асуу. Бурханыг үнэлэн цэгнэх эсвэл шүүмжлэхийг хичээж байгаа хүний мунхаглал мөн түүний үг хийгээд хүний мэргэн ухааныг Бурханаас ирдэгээс дээгүүр тавьж байгааг ярилц.
- Оюутны гарын авлага хуудас 39 дахь схем зурагтай адилхан формат ашигла. Мөнхийн хэтийн төлөв нь мөнх бус байдлын эсрэг байдлын хамгийн сүүлийн хэдэн хэлэлцэх асуудлыг харуулсан ялгаатай дүгнэлтүүдийг гаргахад оюутнуудаар туслуул. Хэрэв та нар үүнийг хийвэл хэлэлцэх асуудлуудыг лавтай урьдаас болгоомжтой бодсон байх хэрэгтэй. Мөнхийн хэтийн төлвийн зэрэглэлд дүгнэлт гаргахад өөрийгөө дэмжүүлэхээр судрууд эсвэл бошиглогчдын тодорхой хэлсэн үгнүүдтэй бай. Дэлхийн хэтийн төлөв Их Эзэний хүмүүсийнхээс их ялгаатай байдгийг харуулсан. Их Эзэний тодорхой ярьсан бараг ямарч сэдэв тухайлбал гэрлэлт, гэр бүл, үр хөндөлт, ёс суртахуун, зарчимч байдал, хүндэтгэлийн өдөр, үзвэр үйлчилгээ зэргийг ашиглаж болно.
- 2 Нифай 9:28–29-ийг оюутнуудтай ярилц.
- Иов 11:7-ийн талаар ярилц. Энэ шүлэгт асуусан асуултуудын хариулт нь хүний хэтийн төл-

вийн үүднээс авч үзвэл юу вэ? Бурханы зүйлсийг мэдэхийн тулд Бурханы сүнс шаардагдана. Дараах шүлэг нь уг үзэл баримтлалыг сайн илэрхийлдэг:

*Хэмжүүр*

*Найз,*

*Чи газар нутгийг*

*Барометрээр хэмждэг үү?*

*Чи таталцлын хуулийг*

*Шалгаснаараа*

*Ойгож чадах уу?*

*Хувийн жин нь маш их*

*Шаврын хөлдөх цэгийг олох уу?*

*Мэдлэгийн дүрмээр бол*

*Бурхан орших нь үгүй.*

*Найз минь,*

*Өөрсдийнхөө багажийг шалга.*

*Бурханыг нээхийн тулд*

*Өөрсдийнхөө төлөвлөгөөгөө*

*Хүний мөн чанараар бус*

*Бурханы мөн чанараар*

*Өөрчлөх ёстой.*

*Цор ганц түлхүүр нь*

*Энэ нь мартагдсан авьяас билэг*

*Чамд буй зүрхний цохилт*

*Одоо мөн дараа нь ч*

*Гараас бултах*

*Оюуныг үргээсэн буюу.*

*Сүнс гэж энэ нь нэрлэгддэг.*

*Найз минь,*

*Бурханыг алдаатай багажаар*

*Чи олох нь үгүй.*

*Чулууны жинг хэн*

*Метрээр хэмждэг вэ?*

*Энэ чинь мунхаглал.*

(Carol Lynn Pearson, *Beginnings*, 2d ed. [Salt Lake City: Bookcraft, 1985], p. 80.)

- Бурхан биднийг амьдралын асуудлууд болон бэрхшээлүүдийг шийдэхдээ Ариун Сүнсний илчлэлтээр удирдагдахыг хүсч төлөвлөдөг. Бидэнд байдаг асуудал нь ихэнхдээ Сүнсний өдөөлтийг таньж ойлгож сурах явдал бөгөөд ийм өдөөлтүүдэд зохистой байх явдал юм. Бид илчлэлтийн зарчмуудад өсөхөөр чармайх үед Сүнсний мэдрэмжтэй хүмүүсээр дамжуулан Их Эзэн бидэнд нэмэлт

---

тусламж өгсөн билээ. Энэ сэдэвт оюутны гарын авлагын 8-3 дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны мэдэгдлийг ярилц. Ахлагч Боид К.Пакерийн дараах мэдэгдэл та нарын ярилцлагад ашиг тустай байх болно:

“Та нар ариун Сүнсээр удирдуулахыг одоо залуудаа суралцаж чадна.

“Төлөөлөгч би ч хөвгүүн байхдаа сонсож байсан нэгэн ижил эх үүсвэрээс ирэх нэгэн ижил сүнслэг урмыг одоо сонсож байна. Одоо дохио нь улам тод болжээ.” (In Conference Report, Oct. 1979, p. 30; or *Ensign*, Nov. 1979, p.21.)

■ Эргэлзээтэй сургаалууд тулгарахад тэд хэрхэн хандахыг оюутнуудаас асуу. Оюутны гарын авлага 8-5 дахь Ахлагч Эзра Тафт Бенсон, Ахлагч Марион Ж.Ромни нарын өгсөн “Хууртагдахаас зугатах шалгалтууд”-ыг ярилц. Энэ шийдвэрт дараах мэдэгдлүүд нь тустай байх болно.

“Сүмийн ямар ч гишүүний хувьд, эсвэл хэн нэгэн хүний хувьд өөрсдөөсөө дээд эрх мэдэл илүү хүмүүсийн төлөө зааварчилгаа хүлээн авах нь Бурханы аргын эсрэг байдаг гэдгийг би та нарт мэдээлж байна. Ийм учраас та тэдэн рүү толгойгоо хандуулах нь буруу гэдгийг ойлгох болно.” (Joseph Smith, *Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [Salt Lake City: Deseret Book Co., 1938], p. 21).

“Биеэ барьдаггүй, хүндэтгэдэггүй, ёс суртахуунгүй, үргэлж гомдоллодог, нааштай юу ч хэлдэггүй нэгний гэрчлэлээс болгоомжил.” (Boyd K. Packer, in Conference Report, Apr. 1974, p. 138; or *Ensign*, May 1974, p. 95).

■ Оюутны гарын авлага 8-6 дахь дугаар 1-ийн доорх удирдамжийн дүгнэлтийг ярилц.

### Заах Зорилго

Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагах нь сонголтыг хязгаарладаггүй, энэ нь эрх чөлөөг нэмэгдүүлдгийг оюутнууд ойлгох ёстой.

### Товч Утгын Жишээ

- А. Бурханлиг хүслийг дагах нь сонголтыг хүчингүй болгодоггүй.
- Б. Сүмийн гишүүд Сүмийн удирдагчдын зөвлөгөө нь Бурханых гэдэг гэрчлэлийг олж авч чадна.

### Заах Зөвлөмжүүд

- Дараах суралцах нөхцөл байдлыг ангид ярилцлагыг эхлэхэд хэрэглэх боломжтой.

Жанис идэвхтэй Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлд өсчээ. Түүний эцэг эх нь Сүмийн удирдагчдыг ямагт асуултгүйгээр дагахыг хичээдэг байв. Гэвч эдүгээ Жанис учраа олохоо больжээ. Тэр их сургуульд суралцаад 1 сар болж байгаа бөгөөд ерөөнийхөө охин Карентай зөрөлддөг болов. Карен Сүмийн Удирдагчдын зөвлөгөөнд үргэлж эргэлзэж байхаар сургагдсан байв. Карен Жанисыг өөрийнхөөрөө бодохгүй байна гэж зэмлэж эхэллээ. Жанис Сүмийн удирдагчдын зөвлөгөөг ямар ч эргэлзээгүйгээр дагах нь буруу байж болох талаар эргэлзэж эхэлжээ. Ингэснээрээ тэр өөрийн сонгох эрх чөлөөг алдаж байгаа хэрэг үү?

- *Сонголт, дуулгавартай байдал* гэдэг үгсийг самбарт бичиж оюутны гарын авлагаас юу сурсныг нь оюутнуудтай ярилц.

- Оюутнуудаасаа дараах зүйлээс тэд алинийг нь чөлөөтэй хийж чадахыг асуу. (Хэрэв тэд ямар нэг юм хийх боломжгүй бол мэдээж тэд үүнийг чөлөөтэй хийж чадахгүй.) Тэд—

1. 1.6 километрийг 6 минутанд гүйж чадах уу? Дөрвөн минутанд?
2. Өөрсдийнх нь төрөлх бус хэлийг ойлгож чадах уу?
3. Компьютер ажиллуулж чадах уу?
4. 45 кг хүнд зүйлийг толгойноосоо дээш өргөж чадах уу? 90 кг-ийг? 135 кг-ийг?
5. Тооцооны асуудлыг шийдэж чадах уу?
6. Өөрсдийнхөө шийдвэрлэх асуудалд илчлэлт хүлээн авч, таньж мөн ойлгож чадах уу?
7. Машин жолоодож чадах уу? Онгоц жолоодож чадах уу?

8. Гэр бүлийн гишүүн буюу найз нөхдийнхөө өвчин болон эрхтний гажгийг эдгээхийн тулд Бурханы хүчийг авчирч чадах уу?
9. Гурван мянган километрийн цаана байгаа хүнтэй ярьж чадах уу?
10. Таван километр газар сэлж чадах уу?

Оюутнуудаас аль үйл ажиллагаануудыг хийж чадахгүйг асуу. Юу эдгээрийг өөр болгож байгааг ярилц. Эдгээр зүйлсийг ажиллах, дасгал хийх, суралцах, дадлага хийх, мэдлэг олох, Сүнслэг байдалдаа анхаарч үз. Бидний өдөр бүрийн сонголт ба үйл ажиллагаанууд нь бидний эрх чөлөөг тэлж эсвэл хязгаарлаж байдгийг ойлгоход нь оюутнуудад тусал. Иохан 8:31–32, 36-г уншиж (Иохан 14:6-г үз.) Аврагч эдгээр шүлгүүдэд юу гэж хэлснийг ярилц. Аврагчийг мэдэж мөн дагах нь биднийг хэрхэн чөлөөтэй болгодог вэ? Тоомсоргүй, дуулгаваргүй байдал нь бидний эрх чөлөөг хэрхэн хязгаарладаг вэ?

- Ахлагч Марион Ж.Ромнийн (оюутны гарын авлага 9-1-ийг үз) сонор сэрэмжтэй байх цамхгийн жишээг ашиглан та нар итгэн найдаж болох юмыг илүү сайн олж мэдэх хэн нэгнийг дагах нь ихэнхдээ маш ухаалаг явдал болдгийг үзүүл.

- Бид өөрсдийн Сүмийн удирдагчдаар зөв удирдуулахын тулд мөн зайлшгүй хэрэгтэй гэрчлэл олж авахын тулд Ариун Сүнсээр дүүргэгдсэн байх ёстой гэдгийг ахлагч Харолд Б.Ли Бригам Янгаас ишлэл авч хэлсэн байдаг. Бид Ариун Сүнсээр дүүргэгдэх ёстой гэсэн Бригам Янгийн иш татсан дөрвөн зүйлийг оюутнуудтайгаа нэгтгэн дүгнэ. (Оюутны гарын авлага 9-5-ыг үз.)

1. Бидний итгэл зөв зүйл дээр (Есүс Христ) дээр төвлөрсөн байх ёстой.
2. Бидэнд (Бурхан ба түүний томилсон үйлчлэгчдэд) итгэх баттай итгэл байх ёстой.
3. Бидний итгэл цэвэр бөгөөд ариун байх ёстой.
4. Бид өөрсдийн дуудлагын үүргээ гүйцэтгэж байх ёстой.

- Оюутны гарын авлага 9-6-гийн дугаар 1-г өгөгдсөн судруудыг ярилц. Эдгээр судруудаа тэмдэглэж, иш татахыг оюутнуудад зөвлө. Адил ойлголтуудыг заадаг өөр судруудыг тэднээр олуул.

- Оюутны гарын авлага 9-6-гийн дугаар 2-ыг ангийн үйл ажиллагаан дахь төстэй байдлыг ашигла. Төстэй байдлуудын хэлсэн үгнүүд тус бүр дээр оюутнууд хэсэгхэн цаасан дээр тэмдэглэгээ хийж үнэлэн жагсааж тэдгээрийн шалтгаануудыг хоорондоо хуваалц.

# Бошиглогчийг Дэмжин Батлах нь Ямар Утгатай вэ?

Бүлэг 10

## Заах Зорилго

Их Эзэнээс өөрийн Сүмийг удирдуулахаар дуудагдсан хүмүүсийг дэмжин батлах боломж Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдэд олгогдсон байдгийг оюутнууд ойлгох ёстой.

## Товч Утгын Жишээ

- Их Эзэн өөрийн Сүмийн удирдагчдыг дэмжин батлах албан ёсны журмыг тодорхойлжээ.
- Дэмжин батлах үйл явц нь дэмжин туслах амлалт юм.
- Гэгээнтнүүд нь Их Эзэний удирдагчдыг үнэхээр дэмжин тусалж байгаа эсэхээрээ шалгаран харагдана.

## Заах Зөвлөмжүүд

■ Оюутнуудтайгаа нийтийн дэмжлэгийн хуулийн талаарх дараах ишлэлүүд: Сургаал ба Гэрээ 26:2; 20:65; 38:34; 124:144-ийг ярилцаж тэмдэглэ. Хэрэв нийтийн дэмжлэгийн хуулийн талаар та нарт дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол *The Doctrine and Covenants Student Manual (Religion 324–25, 1981)*, х. 54, 439–40-ыг үз.

■ Дараах урьдчилан үнэлгээ өгөх асуулт хариултыг явуулж, оюутнууд чинь тодруулахыг хүссэн үр дүн болон асуултуудыг ярилц.


- Сүмийн гишүүд өөрсдийн удирдагчдаар үйлчлэх хүмүүсийг нэр дэвшүүлэх хүч болон эрх мэдэлгүй байдаг. (Үнэн. Энэ хүч нь Сүмийн Ерөнхийлөгч болон түүний томилсон Сүмийн бусад Удирдагчдад өгөгдсөн байдаг.)
- Гэгээнтнүүд нийтийн дэмжлэгийн хуулийн дагуу удирдагчдыг зөвхөн дэмжих ба татгалзахаар сонгох хүчтэй байдаг. (Үнэн.)
- Хэрэв Сүмийн гишүүн удирдагчийг сонгохгүй гэсэн санал өгвөл, тэрээр тухайн албан тушаалд томилох хэн нэгнийг санал оруулж болно. (Худал.)
- Сүмд ямар ч удирдагч дэмжин батлуулах сонгуулиар тэдний зөвшөөрлийг хүлээн авахгүйгээр тэргүүлэхгүй. (Үнэн.)
- Сүмийн удирдагчийн эсрэг хариуцлага тооцсон эсвэл гомдолтой байгаа хэн нэгэн нь дэмжин батлах хурлын өмнө танилцуулж, хэлэх ёстой. (Худал. Сүмийн сахилга батыг Сүмийн ердийн шүүх зохион байгуулагдан авч хэлэлцдэг.)

6. Дэмжин батлуулах саналд тухайн албан хаагчид танилцуулагдах нь зүйд нийцэхгүй гэж үзвэл хурлын үед ил хэлэх буюу эсвэл саналаа хэлнэ. (Үнэн.)

■ Бидний дагахад хэцүү биш зарлигуудын талаар бошиглогч ярих үед түүнийг дэмжин батлах нь хялбар байдаг. Бидний хувийн сонирхлууд, үзэл бодлуудтай түүний зөвлөгөө зөрчилдөх үед бидний итгэлтэй байдлын шалгуур ирдэг. Ахлагч Нил А.Максвелл оюутны гарын авлагын 10-2 дахь хэлсэн үгэндээ хэдэн жишээг зөвлөмж болгожээ. Оюутнууд тэдгээр жишээнүүдийг ярилцаж мөн бошиглогчдоос ирсэн зааврууд ба хувийн үзэл бодлуудын хоорондын зөрчлийг олж болох өөрсдийн ажиглалтын зарим талыг жагсаан бичихийг тэднээс хүс. Эдгээр нь хөгжим, хувцас, болзоо, боловсрол болон эрэгтэй эмэгтэйчүүдийн үүрэг зэрэг болно.

Эдгээр зөрчлийг хэрхэн шийдвэрлэх ёстойг оюутнуудаасаа асуу. Энэ асуултын хариулт нь тэд зөвхөн бошиглогчийг дэмжин батлахаар сонгосон эсвээс тэд үнэхээр түүнийг дэмжин батлахаар гэрээнд орсон эсэхийг харуулснаар гарч ирэхийг тэдэнд хэл.

■ Самбарт дараах диаграммыг зурж оюутнуудаасаа энэ нь үнэнийг төлөөлж байгаа эсэхийг асуу. (Оюутнууд сөрөг туршлагаадаа ярьж сэдвээсээ хазайхгүй байх хэрэгтэй.)



“Бид заримдаа хоёр төрлийн хүмүүстэй сүмд тааралддаг: барилгачид ба дургүйцэгчид. ‘Хүн бүр өөрсдөөсөө би аль ангилалд нь байх ёстой вэ?’ гэж асууг.” (David O. McKay, *Improvement Era*, Mar. 1969, p. 3.)

Барилгачин ба дургүйцэгчид хоёрын хоорондох ялгаа нь юу вэ? Бошиглогчийг дагахад хичээдэг, гэхдээ өөрийн чуулгын удирдагчид, бишоп,

гадасны ерөнхийлөгчийг дэмжиж дагадаггүй эсвэл тогтворгүй хувь хүнийг анзаарч үз. (Оюутны гарын авлагын 10-4-ийн Ахлагч Боид К.Пакерийн хэлсэн үгийг үз.)

- Сонины гарчгууд байсан дараах зүйлсийг самбарт бич:

ХҮГ Сүмийн Ерөнхийлөгчийг  
ХҮГ Эрдэмтэн Шүүмжилж байна  
Уулзалт дээр Сүмийн Гишүүд  
ХҮГ Бодлогыг эсэргүүцэв  
Сонины Тэргүүн Өгүүлэлд Сүмийн  
Гишүүн Бишопын эсрэг Гомдоллов  
Радиогийн Ярилцлагад Гунигтай  
Мормон хүн Гомдоллосон нь

Сүм дэх санаа бодол ба урвалтын хоорондох сонгох эрх чөлөөний зааг хаана байхыг оюутнуудаас асуу. Оюутны гарын авлага 10-5 дахь Ахлагч Жорж Кю.Каннон ба Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит нарын хэлсэн үгийг ярилц. Ахлагч Канноны хэлснээр Сүмийн эрх мэдэлтнүүдээс санаа бодлоороо ялгаатай хэн нэгэнд ямар санаа тавих ёстой вэ? (оюутны гарын авлага 10-6-г үз.) Харолд Б.Лигийн хэлснээр, Сүмийн гишүүд одоо ямар сорилтыг даван туулж байна вэ? Тэр сорилт Сүм дэх урвалтанд хэрхэн нөлөөлдөг вэ?

## Заах Зорилго

Их Эзэний бошиглогчдыг дагах нь биднийг үргэлж сүнслэг өсөлт ба аз жаргалд хөтөлдөг. Тэднийг эсэргүүцсэнээрээ бид урвалт ба зовлонд хөтлөгддөг.

## Товч Утгын Жишээ

- А. Бошиглогчид нь сүнслэг байдлаараа сул дорой хүмүүсээр эсэргүүцэгддэг.
- Б. Сүмийн удирдагчдын эсрэг ярьдаг хүмүүс Бурханыг гомдоож, мөн сүнсээ алддаг.
- В. Бошиглогчдын зөвлөгөөг дагах дуулгавартай хүмүүс бошиглогчийн шагналыг хүртэнэ (Матай 10:41-ийг үз).

## Заах Зөвлөмжүүд

- Дараах судрын ишлэлүүдийг танилцуулж тэдгээрт ямар захиас байгааг оюутнуудаас асуу: Сургаал ба Гэрээ 1:38; Иохан 13:20; Сургаал ба Гэрээ 99:2-4; Матай 10:40; Лук 10:16; Сургаал ба Гэрээ 84:36-37.
- Түүний бошиглогчдыг эсэргүүцдэг атлаа Аврагчийг дагадаг гэж та нар мэдэгдэх эрхгүй тэр байдлын талаар ярилц. Их Эзэнийг үнэхээр хүлээн зөвшөөрч хайрлаж байгаа хүмүүс нь мөн түүний бошиглогчдыг биширч дагах болно. Оюутны гарын авлага 11-2-ын Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны хэлсэн үгний эхний догол мөрийг уншиж бошиглогчийг дагахын ач холбогдлыг онцлон тэмдэглэ. “Та нар Бурханы хуулийг түүний үйлчлэгчдийн үг ба зөвлөгөөг эсэргүүцэж байхдаа баталж байна гэж хэлж чадахгүй” гэсэн Жон Тэйлорын хэлсэн үгийг та нар ашиглаж болно (in *Journal of Discourses*, 7:325, мөн оюутны гарын авлага 11-2-ыг үз).
- Сүмийн Удирдагчийн талаар шүүмжилж эсвэл сөргөөр ярьж байгаа хэн нэгнийг сонссон цагаас хойш хэр зэрэг хугацаа өнгөрснийг оюутнуудаасаа асуу. Тэднийг шүүмжилж байсан хүний тухай бодуул. Тэр хүний гэрчлэл хэр зэрэг хүчтэй байна вэ? Их Эзэний хаант улсыг байгуулахад тэр эрэгтэй эсвэл эмэгтэй хэр зэрэг зүйлийг хийж байна вэ? Энэ хүн нь гол төлөв Их Эзэний сүнстэй байж бусдыг урамшуулдаг уу? Оюутнуудаас ямар төрлийн хүмүүс голдуу Сүмийн удирдагчдыг шүүмжилдгийг асуу. Оюутны гарын авлага 11-1 дахь Ерөнхийлөгч Н.Элдон Таннерийн хэлсэн үгний тухай ярилц. Их Эзэн ийм шүүмжлэлүүдэд хэрхэн ханддаг тухай ярилц (оюутны гарын авлага 11-2 дахь Жорж Кю.Канноны ишлэлийг үз). Сүмийн удирдагчдыг шүүмжилдэг тэдэнд Ариун Сүнс ямар хариулт өгдөг вэ? Шүүмжлэлийн сүнсийг өвөрлөдөг бүх хүмүүст эцэст нь юу тохиолдох вэ? Оюутны гарын авлага 11-3 дахь бошиглогч Иосеф

Смитийн хэлсэн үгийг иш татаж оюутны гарын авлага 11-2, 11-3-т байгаа ах нарын бусад тохирсон мэдэгдлийг ярилц.

- Бригам Янгийн талаар ярьсан ахлагч Эзра Тафт Бенсоны дараах түүхийг хуваалц.

“Түүх нь Бригам Янг хамт олон дундуур жолоодон явж байхдаа байшин барьж байсан хүнийг хараад энгийнээр ханануудаа хоёр дахин зузаан болгохыг хэлсэн. Ерөнхийлөгч Янгийг бошиглогч гэж хүлээн зөвшөөрч тэр эрэгтэй төлөвлөгөөгөө өөрчилж ханануудынхаа зузааныг хоёр дахин болгосон аж. Үүний дараа тун удалгүй тэр сууринд маш их сүйрлийн үр дагавар авчирсан үер болсон ч энэ эрэгтэйн хананууд нь тэсэж өнгөрсөн юм. Байшингийнхаа дээврийг хийж байх үедээ тэр ‘Бурхан минь Бошиглогч Илгээсэн Танд Талархья’ гэдэг дууллыг дуулж байсан ажээ.” (In Conference Report, Apr. 1972, pp. 51–52; or *Ensign*, July 1972, p.61.)

Энэ түүх нь бошиглогчийн зөвлөгөөг яагаад энэ нь өгөгдсөн бүх шалтгаануудыг та нар мэдэхгүй байсан хэдий ч дагахын ашиг тусын талаар юуг зааж байгааг нь асуу. Бошиглогч бидэнд яагаад зөвлөгөө өгдгийг ярилц.

- Оюутны гарын авлагын 11-5 ба 11-6-д бошиглогчдыг дагасан хүмүүст сайн сайхан байдал болон мөнх амьдралыг Их Эзэн амласан гэдгийг хэд хэдэн судруудаар харуулж байна. Эдгээр судруудыг сурч тэмдэглэгээ хийж иш татахыг оюутнуудад зөвлө. Сургаал ба Гэрээний 88:33-ыг ашиглаж Их Эзэн өөрийн амьд бошиглогчдоороо дамжуулан санал болгодог ашиг тусуудыг хүлээн авах эрэгтэйг ярилц. Сүмийн Ерөнхийлөгч сүүлийн чуулган дээр хэлсэн үгнүүдийн зөвлөгөөний хэд хэдэн жишээг иш тат. Зөвлөгөө бүрийг дагахын ашиг тусуудын үр дүнг зөвлөгөөг дагахгүй байхтай харьцуулахыг оюутнуудаас хүс.

- Сонин сэтгүүлүүд, радио телевизийн орчин үеийн мэдээнүүдийг ашиглан дэлхий даяарх хүмүүст буй зарим санаа зовоосон зүйлсийг харуул. Дэлхийн оршин суугчдын ирээдүйн талаар олон хүмүүс итгэл алдарсан мэдрэмжтэй байгааг анхаарч үз. Мөн ихэнхдээ хүмүүст байдаг өөрсдийнхөө хувийн аврал хийгээд мөнх амьдрал олж авахад тэд юу хийх ёстой талаарх тэдний ур чадварын талаар ярилц. Дэлхийд тулгараад байгаа асуудал, бэрхшээлүүдэд нэгэн хариулт байдгийг онцол: “Сүмийн Ерөнхийлөгч уруу хараагаа хандуул” (Harold B. Lee, in Conference Report, Oct. 1970, p. 153). Энэ зөвлөгөө нь үнэн болохыг гэрчил. Зөвхөн Их Эзэний бошиглогчийг дагаж, бошиглогчоор дамжин тэдэнд өгөгдсөн Есүс Христийн сайн мэдээний зарчмуудыг хэрэглэсэн үед, хүн үндсэн аюулгүй байдлын баталгаатай байж чадна. (Гэсэн хэдий ч, мөнх бус байдлын өвчин шаналлаас чөлөөтэй байхыг Их Эзэн амлаагүйг сана. Түүнийг дагах бүгдэд тэр зам мөрд нь дэмжиж мөнх амьдралын зайлшгүй баяр баясгаланг амласан билээ.)

### Заах Зорилго

Сүмийн Чуулгануудыг Их Эзэнээс Гэгээнтнүүдийг өөрсдийн түр зуурын болоод сүнслэг хэргүүдэд хүчирхэгжүүлэхээр үндэслэснийг оюутнууд мэддэг байх ёстой.

### Товч Утгын Жишээ


- А. Ерөнхий Чуулган нь Бурханы оюун ухаан хүслээр ярьдаг амьд бошиглогчдыг сонсох цаг юм.
- Б. Мөнх амьдрал нь бид амьд бошиглогчдын заавруудыг хэр зэрэг сайн сонсож, дуулгавартай дагаснаас хамаардаг.

### Заах Зөвлөмжүүд

п Чуулган болдог шалтгаан, үүнээс тэдний хүртэж чадах хамгийн агуу ашиг тустай зүйлсийг жагсаан бичихийг ангийнхнаасаа хүс. Оюутны гарын авлагын 12-3 дахь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын сүүлчийн хэлсэн үгийг тэмдэглэ.

- Ахлагч Дэвид О.МакКей ерөнхий чуулган зохион байгуулахын дөрвөн зарчмыг өгчээ. (Оюутны гарын авлага 12-1 үз). Самбарт эдгээр дөрвөн зарчмыг бичиж тус бүрт нь зарим нэг жишээнүүдийг жагсаан бичихэд туслахыг оюутнуудаас хүс.
- Дараах үе шатуудыг самбарт эсвэл проекцийн аппаратын тунгалаг ялтсан дээр зурж оюутнуудаас өөрсдийнх нь ерөнхий чуулгантай холбоотой хамгийн сүүлчийн туршлагыг нь үнэлүүлэхийг хүс:

Оролцоогүй эсвэл сонсоогүй



Янз бүрийн хувь хүмүүс ерөнхий чуулганд оролцсон хандлагын тухай Ахлагч Марион Ж.Ромнийн хэлсэн үгийг ярилц (оюутны гарын авлага 12-2-ыг үз).

- Сургаал ба Гэрээний 1:14-ийг оюутнуудтайгаа ярилц. Энэ судар ерөнхий чуулгантай хэрхэн холбогдох вэ?
- Сүмд зохион байгуулагдсан мөн зохион байгуулагдаж байсан төрөл бүрийн чуулгануудыг оюутнуудтайгаа товч тоймлон үз. (Хэсэг, гадас, муж, бүс, ерөнхий.) Эдгээр бүх чуулгануудын зорилго нь үндсэндээ ижил болохыг анхааруул: Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх.
- Оюутны гарын авлага 12-8 дахь дөрвөн асуудлыг оюутнуудаар гүйцээлгэ. Оюутны гарын авлага мөн Сургаал ба Гэрээнээс тэдний үзсэн судруудыг уншсанаар тэдний юу сурснаа тайлагнахыг оюутнуудаас хүс.
- Солт Лейк хотын Табэрнэклд ерөнхий чуулганы хуралдаанд тэд урьд өмнө оролцож үзэж байсан эсэхийг нь оюутнуудаас асуу. Зарим оюутнууд туршлагаа хуваалцахыг хүсч байж болно. Тэд ерөнхий эрх мэдэлтнүүдийн хэн нэгэнтэй уулзаж байсан уу? Тэд юуг мэдэрч байсан бэ? Тэд юу сурсан бэ? Энэ нь тэдний амьдралд ямар үр нөлөөтэй байсан бэ?

# Чуулганы Илтгэлүүдэд Хэрхэн Шинжилгээ Хийж, Мөн Ашиглах вэ?

Бүлэг 13

## Заах Зорилго

Чуулганы илтгэлүүдийг судалснаараа Есүс Христийн сайн мэдээний мэдлэгээ өсгөх болно гэдэгт оюутнууд суралцах ёстой.

## Товч Утгын Жишээ

- А. Чуулганы илтгэлүүд нь амьд бошиглогчдын сургаалуудыг агуулдаг.
- Б. Чуулганы илтгэлүүд нь сүмийн гишүүдэд удирдамж болдог.

## Заах Зөвлөмжүүд

- Ахлагч Харолд Б.Лигийн дараах хэлсэн үгийг унш. “Хожмын Үеийн Гэгээнтнүүд энэ чуулганаас гэр лүүгээ явахдаа тухайн чуулганы илтгэлийг өөртэйгээ авч явахын чухалд ач холбогдол өгөн анхаарвал сайн байх бөгөөд үүнийг ирэх зургаан сарын туршид өөрсдийн явах болон ярихад удирдамж болгох болтугай” (in Conference Report, Apr. 1946, x. 68).

Ахлагч Спенсер В.Кимбаллын: “Хэрэв үүний [Чуулганы] илтгэлүүдэд анхаарал тавихгүй болвол энэ нь цаг эрч хүч мөнгө үрсэн үрэлгэн хөдөлгөөн байх болно” гэж хэлснийг оюутнууддаа сануул. (In the World but Not of It, Brigham Young University Speeches of the Year [Provo, 14 May 1968], x.2). Чуулганы үнэ цэнэ нь хүмүүсийн амьдралыг хэрхэн өөрчлөхөд байдаг. Хэрэв хүмүүс чуулганы захиасуудыг удирдамж мэтээр хэрэглэхийг хүсвэл тэд чуулган дээр хэлсэн үгнүүдийг мэдэж, тунгаан бодож, залбирах ёстойг онцлон хэл.

Оюутны гарын авлагын бүлэг 13-ын удиртгалд ерөнхийлөгч Харолд Б.Лигийн ярьсан үйл явдлыг ярилц. Ерөнхийлөгч Бага Ж.Рюбэн Кларкийн илтгэлийг Ерөнхийлөгч Ли иш татсаныг онцолж ярилц.

- Оюутны гарын авлага 13-4-т өгөгдсөн чуулганы илтгэлүүдийг судлахад зориулсан хэд хэдэн санаа жишээнүүдийг ашиглан тэдгээр арга замуудыг нэгтгэн дүгнэ.
- Энэ хичээлийн гарчиг нь Амьд Бошиглогчдын Заадаг Зүйлс гэдэг бөгөөд энэ нь хичээлийн утга учрыг илэрхийлж байв. Ихэнх хичээл нь амьд бошиглогчдын заадаг зүйлүүдийг судлахад зориулагдах ёстой бөгөөд багшийн гарын авлагын


оршилд үүнийг танилцуулсан болно. Энэ нь хэрхэн хийгдэх талаар хэдэн жишээг дор өгөв:

1. Чуулган дээр хэлсэн үгнүүдийн видео бичлэгүүдийг үзэж өгсөн захиасыг нь ярилц. Олон ярианууд хичээлийн жилийн турш хэлэлцэгдэх болно.
2. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын гишүүдийн хамгийн сүүлийн чуулган дээр хэлсэн үгнүүд тус бүрийг нэг эсвэл хоёр оюутнаар судлуулахаар томил. Оюутан бүрт өөрсдөд нь хамгийн чухал санагдаж байгаа заавруудын талаар ангид тайлагнах цаг гаргаж өг.
3. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын гишүүдийн хамгийн сүүлийн чуулган дээр яриануудын илтгэлийн товч утгыг нь гаргуулахаар оюутнуудыг судлуулахаар томил.
4. Хамгийн сүүлийн чуулганы илтгэлийг судлуулан мөн олон удаа дурдагдсан сэдвүүд хийгээд гарчгуудыг хайхад оюутнуудыг томил. Энэ цаг үед эдгээр нь чухал байгаа шалтгаанууд мөн эдгээр сэдвүүд дээрх сургаалуудыг ангид ярилц.
5. Нийтлэг сонирхлоор сэдэв бүхий жагсаалт бэлтгэ. Эдгээр сэдвүүдэд амьд бошиглогчдын заадаг зүйлүүдийн яриануудыг хувь хүмүүст эсвэл хэсэг оюутнуудад судалгаа хийлгэхээр даалга.
6. Амьд бошиглогчдын хэд хэдэн чухал яриануудыг сонгож оюутан бүрт тэдгээр яриануудыг агуулсан багц бэлтгэ. Тэдэнд яриануудыг уншаад ярилцахад бэлтгэж ангид ирэхийг даалга.
7. Сонирхож байгаа сэдвүүдээ санал болгохыг оюутнуудаас хүс. Хамгийн их давтагдан дурдагдсан сэдвүүдийг сэдэвүүдийг хувь хүмүүс ба хэсгүүдээр сонгуулан мөн үүнээс амьд бошиглогчдын заадаг зүйлүүдийг хайж тайлбарлахыг даалгаад олсон зүйлсийг нь ангид тайлагнуул.
8. *Ensign*-ий өөрсдийн хувиас тодорхой яриануудыг уншиж, тэмдэглэх таваас арван минутыг хичээл бүрийн өмнө оюутнуудад олго. Дараагийн хичээлийн туршид тэдний сэтгэлд лүүд болон асуултуудыг ярилц. Яагаад захиас бүр нь тэдэнд чухал болохыг оюутнуудаас асуу.
9. Амьд бошиглогч бүрийн яриануудын ишлэлүүдийн видео хуурцгуудыг бэлтгэж эсвэл сүүлийн яриануудыг иш татсан тараах материал өгч амьд бошиглогчид бүрийн зарим заадаг зүйлүүдийг давтахад оюутнуудад тусал.



10. Чуулганы хэлсэн үгнүүдийг ангид ярилцаж, чухал хэлсэн үгнүүд, сургаалын тодотголууд, тухайн үеийн асуудлын санаанууд, албан ёсны мэдэгдлүүд мөн бошиглолын тунхаглалуудыг олж тогтоохыг оюутнуудаас хүс.
11. Сүүлийн чуулганы илтгэлүүд дэх сайн мэдээний зарчмуудыг заадаг түүхүүдийг хайж гарчгийн хавтас бэлтгэж эсвэл тэдгээр түүхүүдэд жагсаалт гаргахыг оюутнуудаас хүс.
12. Ерөнхий чуулгануудын хуралдааныг сонгож тэдэнд хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйлсийг тэмдэглэж авахыг оюутнуудад даалга. Тэднийг юу сурч, мэдэрснээ ангидаа хуваалцахыг урь.
13. Оюутнуудаар тэдний сонирхсон сэдвийг нь сонгуул. Тухайн сэдэвт амьд бошиглогчдын заадаг зүйлүүдийг судалж өөрсдийн олсон зүйлсээ хураангуйлан жижиг цаасан дээр бэлтгэхийг даалга.
14. Сүүлийн хэдэн чуулган дээр хэлсэн үгнүүдэд шинжилгээ хийхийг оюутнуудад даалга. Гол санаанууд, судрууд ашигласан байдал, үг хэлэгч Гэгээнтнүүдээс юу хийхийг хүссэн, хэлсэн үг нь тухайн сэдэвт хандах тэдний хандлагад хэрхэн нөлөөлсөн зэрэг зүйлүүдэд оюутнуудаар үнэлэлт өгүүл.

15. Сүүлийн *Ensign*-ийг ангид ашиглахаар хавтас бэлтгэ. Хавтсуудыг зохих газарт амархан буцааж байрлуулж болохуйцаар сар, жил, дугаар зэрэг нь танигдахаар тус бүрийг нь тодоор хаягла (дараах үзүүлэнг үз).



Чуулганы илтгэлийг агуулсан, *Ensign* сэтгүүлийн хамгийн сүүлийн хэдэн хувийг хичээл дээр ашиглахаар байлгах нь тустай байж болно.

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN

